

Дуг	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт	ХБ, ХБЗХТТА	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Үнэлгээ /%/
ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО				
МУ-ын хууль				
1	1	Агаарын тухай 2012-05-17 17.2.4 автобензин, дизель түлш, шингэрүүлсэн шатдаг хий зэрэг түлш, шатахууны стандартыг автотээврийн болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран	ТБГ 1. Автобензин, дизель түлшний Евро стандартын жишигт нийцсэн үндэсний стандартын төслийг боловсруулах ажлын хэсэг Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим дээр байгуулагдсан. Энэхүү ажлын хэсэгт автотээврийн болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөлөл оролцсон ба стандартын төслийг боловсруулан, Стандартчилал хэмжилзүйн газрын техникийн хорооны 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус төсөл Стандарчиллын Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулах шатандаа явж байна. /Биелэлт-90%/ 2. Хийн түлшний олон улсын NFPA-58 стандартыг орчуулуулж дууссан ба уг орчуулга дээр үндэслэн Үндэсний стандартын төсөл боловсруулах ажил хийгдэж байна. /Биелэлт-70%/ 3. Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын нормыг боловсруулан Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. /Биелэлт-100%/	50
2	2	ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 7.1.4 нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах; газрын тосны бүртгэл, тооцоо; газрын тосны салбарыг хөгжүүлэх сан; уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг батлах;	ТБГ Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журмын төсөл, Газрын тосны бүртгэл, тооцооны журмын төслийг боловсруулж, дотоодын зөвлөхийг ажиллуулсан. Боловсруулсан төсөл дээр АНУ-ын худалдааны яамны зөвлөхүүдээс саналыг авч тусган АНУ-ын худалдааны яам, Монгол дахь элчин сайдын яамтай хамтран семинар зохион байгуулсан. Журамтай холбогдуулан 2 удаа АНУ-ын хуулийн болон санхүүгийн зөвлөхүүдтэй видео конференц зохион байгуулсан бөгөөд сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. Уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалттай холбогдсон харилцааг зохицуулах тухай журмыг боловсруулж, мэргэжлийн холбоод, шинжлэх ухааны байгууллагуудаас санал авч тусган, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн 2015 оны 5-р сарын 22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Журмын төсөлд яамдаас санал авч холбогдох саналыг тусган Засгийн газрын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 295 дугаар тогтоолоор батлуулсан. Уг журмыг Уул уурхайн /хуучин нэрээр/ яамны цахим хуудсанд www.mn.gov.mn байршуулсан. Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2014.01.23-ны өдрийн хуулиар “Газрын тосны салбарыг хөгжүүлэх сан”-г хассан. Иймд тус журмыг боловсруулах шаардлагагүй болсон.	50
2	3	ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 8.1.3 газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлага; газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлага; гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай; газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах; газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмыг батлах;	ТБГ Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагын төслийг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч хянан тусгасан. Журмын төслийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгож, ТЗУГ-т дотоод албан бичгээр хүргүүлсэн. 1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавих шаардлагыг эцэслэн боловсруулж, мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.03.10-ны 49 тоот тушаалаар батлуулсан. Мөн Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд журмын дагуу бүртгүүлж, Уул уурхайн /хуучин нэрээр/ яамны цахим хуудсанд www.mn.gov.mn байршуулсан. 2. Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавих шаардлагыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагаас санал авч төсөлд тусган 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.09.04-ны өдрийн 197 дугаар тушаалаар батлуулсан. 3. Гэрээлэгчийг сонгон шалгаруулах тухай журмыг боловсруулж, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны 202 тоот тушаалаар батлуулан Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд 2014.10.15-ны өдөр нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын жагсаалтад бүртгүүлсэн. 4. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмыг боловсруулж, салбарын мэргэжлийн холбоод, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.09.04-ны өдрийн 196 дугаар тушаалаар батлуулсан. 5. Газрын тос, уламжлалт бус газрын тосны чиглэлээр мэргэжлийн зэрэг олгох журмын төслийг боловсруулж, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 53 дугаар тушаалаар батлуулсан. Уг журмыг ХЗЯ-аар /хуучин нэрээр/ бүртгүүлж, УУЯ-ны /хуучин нэрээр/ www.mn.gov.mn цахим хуудсанд байршуулсан.	90

	4	ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 8.1.8 газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;	ТБГ	“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам”-ыг боловсруулах БОНХАЖ /хуучин нэрээр/, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2015.03.24-ний өдрийн 62/А-131 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг ажиллаж, төслийг боловсруулан БОНХАЖ-ийн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар 2015.11.11-ний өдөр хэлэлцүүлсэн. Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар нийт 2 удаа хэлэлцүүлэн УУС-ын /хуучин нэрээр/ тушаалаар батлуулж, журмын дагуу Хууль зүйн /хуучин нэрээр/ яаманд бүртгүүлэхээр холбогдох материалыг бүрдүүлж хүргүүлсэн.	90
	5	ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2014-07-01 8.1.9 газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах;	ТБГ	“Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-г боловсруулж, холбогдох байгууллага, аж ахуй нэгжүүдээс саналыг авсан. Дүрмийн төслийг Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр яамны удирдлагуудад журмыг батлах тухай тушаалын төслийг хамт танилцуулан санал авч тусгасан. Журмын төсөлд санал авахаар хуулийн хэлтэст хүргүүлсэн.	50
ЗГ-ЫН ТОГТООЛ					
1	1	Төсвийн хөрөнгөөр барьсан зарим барилга байгууламжийн тухай 2014-05-21 №161 1 “ДЦС-2” төрийн өмчит хувьцаат компанийг түшиглэн жилд 210,000 тонн хагас коксон түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий цогцолбор байгуулах төслийн гүйцэтгэл, зардлын тооцоо, хөрөнгийн үнэлгээг Үндэсний аудитын газар, тусгай зөвшөөрөл бүхий хөндлөнгийн үнэлгээчээр үнэлүүлж улсын комисс хүлээн авах арга хэмжээг зохион байгуулахыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Эрчим хүчний сайд М.Сономпил нарт даалгасугай.	ТБГ	Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 2014 оны 190 дүгээр тушаалаар “ДЦС-2 ТӨХК-ийг түшиглэн жилд хоёр зуун арван мянган (210000) тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төсөл”-ийн хүрээнд баригдсан шахмал түлшний цех, агуулах, шингэн шилний үйлдвэрийн барилга байгууламжийн гүйцэтгэлд дүгнэлт гаргаж ашиглалтад оруулах Улсын комиссыг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулсан. Уг комисс нь Техникийн комиссоос гаргасан шийдвэр болон холбогдох баримт бичгийг судлахын зэрэгцээ үйлдвэрлэлийн явц байдалтай танилцаж дээрх барилга байгууламжуудыг ашиглалтад авах тухай шийдвэр гаргаж ажилласан. Уул уурхайн яам /хуучин нэрээр/-аас Засгийн газрын 2014.05.21-ний өдрийн 161 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд барилга байгууламжийг улсын комисс хүлээн авсны дараа төслийн гүйцэтгэлийн зөрүү мөнгийг гүйцэтгэгч “Аморе интернейшнл” ХХК-иар нөхөн төлүүлэх арга хэмжээ авахаар төслийн гүйцэтгэгчтэй гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулж ажиллав. Эрдэс баялаг, эрчим хүчний яам /хуучин нэрээр/, “Аморе интернэйшнл” ХХК-ийн хооронд 2010 оны 07 дугаар сарын 09-ны өдөр байгуулсан 10/56 тоот гүйцэтгэлийн гэрээг дүгнэх ажлын хэсэг 2014 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Аж үйлдвэрийн /хуучин нэрээр/ сайд, Эрчим хүчний /хуучин нэрээр/ сайд, Уул уурхайн /хуучин нэрээр/ сайдын 81/67/79 тоот хамтарсан тушаалаар байгуулагдан гэрээг дүгнэсэн. Уг асуудал цаашид Эрчим хүчний яаманд хамаарах УУХҮЯ-ны хяналтаас хасуулах саналтай байна.	100
2	2	Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох, шатахууны нөөцийн талаар авах арга 2014-09-18 №303 3.3. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 83350 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэх арга хэмжээ авч, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт даалгасугай.	ТБГ	Тогтоолын дагуу тухай жилд нөөцийг бүрэн бүрдүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Засгийн газрын 2015 оны 412 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын 2016 оны нөөцийг 84720 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнээс доошгүй байхаар тогтоосон. Уг ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Газрын тосны газар /хуучин нэрээр/ аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан. 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 44 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 49, Аи-92 автобензин 50, дизелийн түлш 50, ТС-1 онгоцны түлш 27 хоногийн нөөцтэй байгаа тул дээрх үүргээ бүрэн ханган ажиллаж байгаа болно. Нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2015 оны 412 дугаар тогтоолоор уг тогтоол хүчингүй болсон. Хяналтаас хасуулах саналтай. (Биелэлт-100%)	100

3	3	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2015-03-02 №112</p> <p>3 Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2015 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.</p>	ТБГ	<p>Уг тогтоолд тусгагдсан аж ахуйн нэгжүүдийн гадаадаас авсан ажиллах хүч, мэргэжилтэнүүд нь хууль, тогтоомжийн дагуу ажиллаж хугацаандаа гарсан бөгөөд сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг 2015.12.24-ний 1/2473 тоотор Хөдөлмөрийн /хуучин нэрээр/ яаманд уламжилсан. Хяналтаас хасуулах.</p>	100
4	4	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2015-03-23</p> <p>3 Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2015 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.</p>	ТБГ	<p>Уг тогтоолд тусгагдсан аж ахуйн нэгжүүдийн гадаадаас авсан ажиллах хүч, мэргэжилтэнүүд нь хууль, тогтоомжийн дагуу ажиллаж хугацаандаа гарсан бөгөөд сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг 2015.12.24-ний 1/2473 тоотор Хөдөлмөрийн /хуучин нэрээр/ яаманд уламжилж шийдвэрлүүлсэн. Хяналтаас хасуулах.</p>	100
5	5	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай 2015-04-27</p> <p>2 Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2015 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.</p>	ТБГ	<p>Уг тогтоолд тусгагдсан аж ахуйн нэгжүүдийн гадаадаас авсан ажиллах хүч, мэргэжилтэнүүд нь хууль, тогтоомжийн дагуу ажиллаж хугацаандаа гарсан бөгөөд сунгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг 2015.12.24-ний 1/2473 тоотор Хөдөлмөрийн /хуучин нэрээр/ яаманд уламжилж шийдвэрлүүлсэн. Хяналтаас хасуулах.</p>	100
6	6	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийн эрх, үүргийг хэсэгчлэн шилжүүлэх тухай 2015-05-04 №172</p> <p>2 Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг шилжүүлэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэнд даалгасугай.</p>	ТБГ	<p>Тогтоолын дагуу Газрын тосны хайгуулын Богд IV, Онги V талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр гэрээлэгчийн хүлээсэн эрх, үүргийг Би Жи Монголиа холдингс лимитэд компанид хэсэгчлэн шилжүүлсэн. 2015, 2016 оны хайгуулын ажлын хөтөлбөр, төсвийг батлуулж, үйл ажиллагааг явуулж байна.</p>	100

7	7	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай 2015-06-08</p> <p>2 2. Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2015 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд Д.Цогтбаатар, Зам, тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.</p>	ТБГ	<p>2015 онд гадаадаас авч ажиллуулсан ажиллах хүч, мэргэжилтнийг буцаан гаргах ажлыг зохион байгуулсан. Шинээр орж ирэх ажиллах хүчний асуудлыг Хөдөлмөрийн /хуучин нэрээр/ яаманд уламжилж шийдвэрлүүлсэн. Хяналтаас хасуулах.</p>	100
8	8	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх тухай 2015-07-20 №300</p> <p>3 “Сансарын геологи хайгуул” ХХК болон “Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК-тай гурван талт гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэнд даалгасугай.</p>	ТБГ	<p>2016 оны эхний улирлын байдлаар Сулинхээр ХХIII талбайд “Шунхлай энерги” ХХК, Номгон IX талбайд “Өмнөд Монголын газар нутгийн тос” ХХК, Дарьганга ХХIV талбайд “Монголиа Шин И Энержи” ХХК- тай тус тус БХГ-г шинэчлэн байгуулаад байна. Борзон VII талбайд “Импайр Газ Монголиа” ХХК, Богд IV, Онги V талбайд “Капкорп Монголиа” ХХК, Сүхбаатар ХХVII талбайд Вольф петролиум ХХК-тай тус тус БХГ-г шинэчлэн байгуулах талаар хэлэлцээрүүд хийгдэж байна. Гэрээний төсөлд талбай буцаах, захиргааны зардлын хувь хэмжээ, үлдсэн хугацаанд заавал хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, удирдлагын зардлын шатлал, бүтээгдэхүүн хуваах шатлал, олборлолт нэмэгдүүлсний шатлал зэргийг гэрээлэгчтэй хэлэлцэн шинэчлэх ажлууд хийгдсэн. Мөн хайгуулын үлдсэн хугацаа болон эскроу дансанд байршуулах мөнгөн хөрөнгө, тусгай зөвшөөрлийн болон гэрээнд заасан бусад төлбөрүүдийн төлөх хугацаа, засгийн газарт тавих ашигтай санал зэрэг асуудлыг тусгасан харилцан ойлголцлын санамж бичгийг гэрээ тус бүрт байгуулсан.</p>	70
9	9	<p>Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2015-10-19 №412</p> <p>3 Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг 84720 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.</p>	ТБГ	<p>Засгийн газрын 2015 оны 412 дугаар тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын 2016 оны нөөцийг 84720 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнээс доошгүй байхаар тогтоосон. Уг ажлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Газрын тосны газар /хуучин нэрээр/ аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 44 хоногийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцтэй байгаа бөгөөд үүнээс А-80 автобензин 49, Аи-92 автобензин 50, дизелийн түлш 50, ТС-1 онгоцны түлш 27 хоногийн нөөцтэй байгаа тул дээрх үүргээ бүрэн ханган ажиллаж байгаа болно. Мөн 2017 оны газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох танилцуулгын хамт боловсруулж, яамдуудаас санал авч нэгтгэн Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 147 дугаар тогтоолоор батлуулсан. Уг тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нөөцийг 81900 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнээс доошгүй байхаар тогтоож 2015 оны 421 дугаар тогтоолыг хүчингүй болсон. Хяналтаас хасуулах саналтай.</p>	100
10	10	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах эрх олгох тухай 2015-11-02 №431</p> <p>2 Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлан газрын тосны тухай хууль тогтоомж болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгасугай.</p>	ТБГ	<p>Газрын тосны хайгуулын Тариач-ХV талбайд Газрын тосны газар /хуучин нэрээр/, “Чайна Голден Сий Петролеум Эксплорейшн Корпорейшн” ХХК-ийн хооронд байгуулсан БХГ-г цуцалж, талбайг буцаан авах ажлын хэсгийг УУЯ /хуучин нэрээр/, БОНХАЖ-ын /хуучин нэрээр/ яам болон холбогдох байгууллагууд оролцсон ажлын хэсгийг байгуулахаар ажиллаж байна.</p>	10

11	11	<p>Гадаадаас 2016 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай 2015-11-02 №432</p> <p>5 Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.</p>	ТБГ	Тус тогтоолд заасан хувийг уул уурхайн салбарт гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдэд тодорхойлолт гаргахдаа баримтлан ажиллаж байна.	100
12	12	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай 2015-12-07</p> <p>2 Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2016 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ нарт даалгасугай.</p>	ТБГ	2016 онд гадаадаас авч ажиллуулсан ажиллах хүч, мэргэжилтнийг буцаан гаргах ажлыг зохион байгуулсан. Шинээр орж ирэх ажиллах хүчний асуудлыг хөдөлмөрийн яаманд уламжилж шийдвэрлүүлсэн. Биелэлт 100% хасах	100
13	13	<p>Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх тухай 2016-01-11 №41</p> <p>3 Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлэх талаар “Апекспро инвестмент лимитед” ХХК болон “Монголиа шин ий энерги” ХХК-тай гурван талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэнд үүрэг болгосугай.</p>	ТБГ	“Апекспро инвестмент лимитед” ХХК болон “Монголиа шин ий энерги” ХХК, ГТГ /хуучнаар/ Газрын тосны тухай хуулийн 14.5-д заасны дагуу гурван талт гэрээ байгуулж, гэрээлэгчийн эрх үүргийг “Монголиа шин ий энерги” ХХК-д бүрэн шилжүүлсэн. Бүрэн биелсэн. хяналтаас хасуулах саналтай.	100
14	14	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай 2016-02-01 №84</p> <p>3 Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2016 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Зам, тээврийн сайд М.Зоригт, Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт даалгасугай.</p>	ТБГ	2016 онд гадаадаас авч ажиллуулсан ажиллах хүч, мэргэжилтнийг буцаан гаргах ажлыг зохион байгуулсан. Шинээр орж ирэх ажиллах хүчний асуудлыг Хөдөлмөрийн /хуучин нэрээр/ яаманд уламжилж шийдвэрлүүлсэн. Биелэлт 100% хасах	100

15	15	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай 2016-03-28 №181</p> <p>2 Энэ тогтоолын дагуу ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2016 онд буцаан гаргах ажлыг зохион байгуулж, дүнг Хөдөлмөрийн яаманд хүргүүлэхийг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Зам, тээврийн сайд М.Зоригт, Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай.</p>	ТБГ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжилж, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгосон. (Биелэлт-100%)	100
16	16	<p>Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай 2016-08-24</p> <p>2 Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах ажилтныг 2016 онд буцаан гаргаж, дүнг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд мэдээлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж нарт үүрэг болгосугай.</p>	ТБГ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд уламжилж, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгосон. (Биелэлт-100%)	100
17	17	<p>Тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2016-10-05</p> <p>2 Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид үүрэг болгосугай.</p>	ТБГ	Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ нэмэгдсэн, дотоод дахь төгрөг ам.долларын эсрэг эрс суларсан зэрэг гадаад дотоод хүчин зүйлсээс хамааран шатахууны жижиглэнгийн үнэ өсөх нөхцөл үүссэн тул "Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл"-ийн хоёрдугаар хуралдааныг 11 сарын 23-ны өдөр хуралдуулж, холбогдох "Зөвлөмж"-ийг Засгийн газарт хүргүүлсэн. Уг "Зөвлөмж"-өөр "Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгийн ханш, америк долларын эсрэг эрс суларсан, хилийн үнэнд өөрчлөлт орсонтой холбогдуулан дотоодод борлуулж буй шатахууны жижиглэнгийн үнийн тогтвортой байдлыг хадгалан, автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг оновчтой хэлбэрээр тогтоон зохицуулалт хийх нь зүйтэй" гэсэн болно. Үүний үр дүнд Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 166 дугаар тогтоолоор автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг тодорхой хэмжээгээр бууруулан дотоодод борлуулж буй шатахууны жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах арга хэмжээ аваад байгаа хэдий ч аж ахуйн нэгжийн алдагдалыг бүрэн хааж чадахгүй байна. Мөн уг тогтоол гарсанаар 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг хүчингүй болсон. Хяналтаас хасуулах саналтай. (Биелэлт-100%)	100
18	18	<p>Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2016-11-16</p> <p>2 Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл бүхий компаниудын нөөцийг 81 900 тонн буюу 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээнд хүргэж бүрдүүлэх ажлыг 2017 оны 3 дугаар сарын 1-ний дотор зохион байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид даалгасугай.</p>	ТБГ	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар нь газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх 16 аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хэлэлцээр хийх асуудлаар уулзалт зохин байгуулан ажиллаж байна.	30
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл					

1	1	<p>2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тэмдэглэлд 2013-07-06 2 XIII. 2. "Газрын тосны олборлолт, экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX талбайгаас Монгол, Хятадын хилийн Баянхошуу боомтын чиглэлд 210,7 км хатуу хучилттай авто зам барих ажлыг шуурхай зохион байгуулж, холбогдох зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгож ажиллахыг Зам тээврийн сайд А.Гансүх, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нарт тус тус даалгав.</p>	<p>Хатуу хучилттай замын 50 гаруй км далангийн ажил хийгдсэн. Үлдсэн хэсгийн гүйцэтгэгчийг сонгох асуудал ЗТЯ-аас /хуучин нэрээр/ зөвшөөрөл олгогдохгүй байгаагаас хойшлогдож байна. УУЯ /хуучин нэрээр/, ГТГ-ын /хуучин нэрээр/ зүгээс шалтгаалах зүйл байхгүй бөгөөд ажлыг шуурхайлах талаар хүсэлтийг удаа дараа ЗТЯ-нд хүргүүлсэн.</p>	30
2	2	<p>2014 оны 7 сарын 9-ний 38 дугаар тэмдэглэл 2014-07-09 ХҮИ.3 Шивээхүрэн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөтгөж, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний тухай Уул уурхайн сайд Д.Ганхуяг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Нарийнсухайтын нүүрсний бүлэг ордоос Шивээхүрэн боомтоор тээвэрлэх нүүрсний хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хилийн боомтоор нэвтрэх авто машины ачааллыг бууруулах, хоёр улсын хилийн гаалийн хамтарсан хяналт хийх боломжийг бүрдүүлэхтэй холбогдуулан нүүрс экспортлогч компаниуд болон нүүрс шилжүүлэн ачих байгууламж, зам барьж байгаа аж ахуйн нэгжүүдтэй тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Зам, тээврийн сайд А.Гансүх, Гадаад харилцааны сайд Л.Болд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</p>	<p>Нарийнсухайтын нүүрсний ордод үйл ажиллагаа явуулж байгаа нүүрс экспортлогч компаниуд болон нүүрс шилжүүлэн ачих байгууламж, зам барьж байгаа аж ахуйн нэгжүүдтэй холбогдож, Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэх тогтоолын төслийг боловсруулж, холбогдох яамдуудаас санал авахаар албан бичгийн төсөл боловсруулсан.</p>	10
3	3	<p>2014 оны 8 сарын 28-ний 46 дугаар тэмдэглэл 2014-08-28 1.2 автобензин, дизелийн түлшний хангамж болон дотоодын жижиглэн худалдаалах үнийг тогтвортой байлгах талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг илүү оновчтой, шинэлэг болгох санал боловсруулж Засгийн газарт оруулах</p>	<p>Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 15 дугаар тогтоолоор "Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл"-ийг байгуулан холбогдох асуудлыг хэлэлцэн "Зөвлөмж"-ийг Засгийн газарт хүргүүлэн тогтмол арга хэмжээ авч ажиллаж байна. (Биелэлт-100%)</p>	50

4	4	<p>2014 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр 50 дугаар тэмдэглэл 2014-09-25</p> <p>ҮИИ.6 Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 40 дүгээр захирамжаар байгуулагдсан Оросын Холбооны Улсаас Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг шугам хоолойгоор нийлүүлэх, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг онгоцны түлшээр хангах, газрын тосны хайгуулын ажилд оролцох зэрэг Оросын Холбооны Улсын Роснефть компанийн ерөнхийлөгч И.И.Сечиний тавьсан саналыг судалж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн танилцуулгыг Уул уурхайн сайд Д.Ганхуяг Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Газрын тосны газар болон Роснефть компанийн хооронд 2014 оны 5 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан “Түлш, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай протокол”-д тусгагдсан саналуудыг ажил хэрэг болгох талаар анхаарч ажиллахыг Ажлын хэсгийн дарга Г.Өлзийбүрэнд даалгав.</p>	<p>“Роснефть” компанийн Ерөнхийлөгч И.И. Сечин 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсад ажлын айлчлал хийж, Монгол улсын ерөнхий сайд Н.Алтанхуяг, Уул уурхайн сайд Д.Ганхуяг нартай уулзалт хийсэн. Уулзалтаар ОХУ-аас Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг шугам хоолойгоор нийлүүлэх, Хөшигтийн хөндийд баригдаж байгаа олон улсын онгоцны буудалд агуулах барих, онгоцны түлшээр хангах, газрын тосны хайгуулын ажилд оролцох зэрэг 3 санал тавьсан. Уг тавьсан саналын дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар монголын талын Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг ОХУ-ын “Роснефть” компаниас ирүүлсэн Санамж бичгийн төсөл дээр ажиллаж, уг төсөлд манай талын саналыг тусгасан хариуг хүргүүлж, харилцан санал солилцсоны үндсэн дээр 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ОХУ-ын Санкт Петербург хотноо болсон олон улсын эдийн засгийн Форумын үеэр “Түлш, эрчим хүчний салбарт хамтран ажиллах тухай Протокол”-д Оросын талаас “Роснефть” компанийг төлөөлөн И.Сечин, Монголын талаас ГТГ-ын дарга Г.Өлзийбүрэн нар гарын үсэг зурсан болно. Мөн “Роснефть” компани болон Монгол улсын газрын тосны бүтээгдэхүүний томоохон импортлогч компаниуд болох “НИК”, “Магнай трейд”, “Шунхлай” компаниудын хооронд нефтийн бүтээгдэхүүн нийлүүлэх тухай 5 жилийн гэрээнд гарын үсэг зурагдсан болно. /Биелэлт 100%/</p>	100
5	5	<p>2015 оны 07 дугаар сарын 20-ны өдөр 43 дугаар тэмдэглэл 2015-07-20</p> <p>ХҮ. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг шилжүүлж авсан “Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК нь “Сансарын геологи хайгуул” ХХК-ийн 2014 онд төлөвлөсөн хайгуулын ажлыг 2015 онд багтаан нөхөн хийж дуусгах, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төлөх зэрэг асуудлыг 3 талт гэрээнд тусган хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэнд даалгав.</p>	<p>Өмнөд монголын газар нутгийн тос” ХХК нь “Сансарын геологи хайгуул” ХХК-ийн 2014 онд төлөвлөсөн хайгуулын ажлыг 2015 онд багтаан нөхөн хийж дуусгах, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшууллыг хугацаанд нь төлөх зэрэг асуудлыг 3 талт гэрээнд тусган хяналт тавьж ажиллаж байна.</p>	100
6	6	<p>2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 12 дугаар тэмдэглэл 2016-02-29</p> <p>ХҮ. 2. Бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх явцад үүссэн зарчмын зөрүүтэй асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд үүрэг болгов.</p>	<p>Тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд Газрын тосны хайгуулын Ар булаг ХХИХ талбайн БХГ-г шинээр батлагдсан БХГ ний загварт нийцүүлэн батлуулсан. Өмнө байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг гэрээний загварт нийцүүлэн шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны А/57 дугаар тушаалаар байгуулж, гэрээлэгчидтэй хэлэлцээрийг эхлүүлсэн. Биелэлт 80%</p>	30

7	7	<p>2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 15 дугаар тэмдэглэл 2016-03-14</p> <p>IV. Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатарын санаачлан боловсруулсан Шатахууны эрсдэлийн нөөцийн тухай хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу хууль санаачлагчтай тохиролцсоны үндсэн дээр хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулах ажлыг зохион байгуулахыг Уул уурхайн сайд Р.Жигжидэд даалгав.</p>	<p>2017 оноос "Хууль тогтоомжийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн, яамны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбоотойгоор уг хуулийн төслийг дахин боловсруулах. Мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020 онд "Газрын тосны бүтээгдэхүүний тухай" хуулийг шинэчлэн боловсруулах талаар саналаа өгсөн бөгөөд УУХҮЯ-ын сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулан ажилах тул тус хуулийн төслийг дахин хэлэлцэх болно.</p>	10
8	8	<p>2016 оны 06 дугаар сарын 6-ны өдөр 31 дүгээр тэмдэглэл 2016-06-06</p> <p>VII. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахууны тухай асуудлыг хэлэлцээд Газрын тосны газар болон шатахуун нийлүүлэгч компаниудын хооронд байгуулсан "Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахууны сэлгэх гэрээ"-ний хугацааг сунгахыг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэнд даалгав.</p>	<p>Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн шатахуун сэлгэх гэрээний хугацааг сунгахаар тус яамны хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны газар /хуучнаар/ ажиллаж, гэрээг сунган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. хяналтаас хасуулах саналтай. /Биелэлт-100%/</p>	100

ҮАБЗ-ийн зөвлөмж

1	1	<p>Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх төслүүдийн тухай 2012-03-27</p> <p>1 2011 оны УИХ-ын 65 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого"-ын 3 дугаар зүйлийн 4.6-д "Нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн судалгаа хийх, бүтээгдэхүүн худалдан авах болон төслийн санхүүжилтэд Засгийн газраас баталгаа гаргах асуудлыг судлах" заалтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, технологийн сонгон шалгаруулалтын зарчмыг баримталж, төсөл хэрэгжүүлэгчид бүтээгдэхүүн худалдан авах баталгаа</p>	<p>Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2014 оны 1 дүгээр сард нүүрснээс шингэн түлш гаргах төслийг ХБНГУ-ын технологийг ашиглан хэрэгжүүлэх тухай ЗГ-ын 246 тоот тогтоолын дагуу төсөл хэрэгжүүлэгч "СИ ТИ ЭЛ Монголиа" 100% төрийн өмчит компанийг байгуулсан. Төслийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын ҮХААЯамны санаачилгаар, 2014 оны 04 дүгээр сард төсөл хэрэгжүүлэгч төрийн өмчит компанийн 49 хүртэл хувийг хувийн хэвшлийнхэнд санал болгосон. Санал болгосон хувийн дагуу ХБНГУ-ын "GME Energy Generation" ХХК төсөлд хамтран ажиллах санал ирүүлэн Төрийн өмчийн хороо болон "GME Energy generation" ХХК-ын хооронд хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулагдаж, 51% Төрийн өмчит "ГерМон газ" ХХК байгуулагдсан. Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд зааснаар эхлээд төсөл хөгжүүлэх шатанд "ГерМон газ" ХХК нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудад итгэмжлэгдсэн төслийн үнэлгээ /project due diligence/ бүхий судалгааны ажил хийж, банкинд итгэмжлэгдсэн ТЭЗҮ /bankable Feasibility study/ боловсруулах үүрэг хүлээсний дагуу "ГерМон газ" ХХК нь ХБНГУ-ын нүүрс хийжүүлэх технологи болох "Lugri Fixed Bed Dry Bottom Process" болон нийлэг хий шингэрүүлэх "Fischer@Tropsch" технологиудыг ашиглан Шивээ-Овоогын ордын нүүрснээс жилд 650 мянган тонн бензин, 84 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулсан.</p>	10
---	---	---	---	----

		2 Нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх талаар аж ахуйн нэгжүүдээс гаргасан санал, санаачлага, төслийн хэрэгжилтийн явц, холбогдох баримт бичгийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах;	MCS", "МАК", , "Си Ти Эл" ХХК-иуд Нүүрсийг гүн боловсруулж, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх ТЭЗҮ боловсруулж, Уул уурхайн яамны Эрдэс баялагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. "MCS" ХХК нь БНСУ-ын "Posco" компанитай энэ төсөл дээр хамтран ажиллах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр гэрээ хэлэлцээрийг хийж дуусгаад байна. "МАК Си Ти Эл" ХХК нь мөн санхүүжилтийн асуудлаар БНХАУ, Герман улсуудын хөрөнгө оруулагчидтай яриа хэлэлцээрийг хийж байна. "Цэцэнс Майнинг энд Энержи" ХХК нь нүүрс шингэрүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан ба санхүүгийн асуудал шийдэгдээгүй байна.	10
2	3	Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах тухай 2012-12-14 2 Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын Сүхбаатар-XXVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг "Вульф Петролеум"	Сүхбаатар XXVII талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан "Вульф петролеум" ХХК-д газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 2013 оны 06-р сарын 06-ны өдрийн Уул уурхайн сайдын 122 дугаар тушаалаар олгов. Биелэлт 100% Хяналтаас хасуулах саналтай.	100
3	4	Газрын тос боловсруулах үйлдвэрийн тухай 2014-03-17 1 Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах.	Дархан газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Япон улсын ВИС банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр УУЯ /хуучин нэрээр/ ажилласан. Уг ажлын хүрээнд үйлдвэрийн Техникийн зураг төслийн ажил (ТЗТА)-ыг гүйцэтгэх болон уг ажлын төлбөрийн тухай гэрээг 2013 оны 5 дугаар сард байгуулж гэрээний дагуу Японы Тоёо инженеринг корпорациас Техникийн зураг төслийг (7 боть, 9000 хуудас, 700 зураг схем) 2014 оны 2 дугаар сард хүлээн авсан. Техникийн зураг төсөл боловсруулсны дараагаар тус Тоёо Инженеринг үйлдвэрийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд гарах зардал нь төсөвлөж байснаас 2 дахин нэмэгдсэн тул үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэх боломжгүй гэдгээ төслийн ерөнхий зохицуулагч Марубени корпорацид мэдэгдсэн. Ингээд Марубени корпораци Дарханы үйлдвэрийг барих асуудлыг Японы Чиёда компанид тавьж үйлдвэр барих асуудлаар тохиролцоонд хүрсэн. Чиёда компани нь Тоёо инженеринг корпорацийн хийсэн ТЗТА-ыг дахин боловсруулах, өөрсдийн тооцоо судалгаанд үндэслэсэн шинэчлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнд шаардлагатай 2,3 сая ам.долларыг Монголын Засгийн газраас гаргуулах хүсэлтийг тавьсан. Д-ГТБҮ байгуулах төслийг ҮАБЗ-өөр хэлэлцүүлсэн. 2014 оны 3-р сарын 17-нд ҮАБЗ-өөс "Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах" Зөвлөмжийг гаргасан. Д-ГТБҮ-ийн төслийг Монгол улсын төр засгаас гаргасан бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан аж үйлдвэрийн шинэ төвүүд болон газрын тосны ирээдүй бүхий ордуудтай аль болох ойр байршуулах боломжийг судалж байж шийдвэрлэхээр болсон. Тус асуудал чиг үүргийн хувьд Аж үйлдвэрийн /хуучин нэрээр/ яаманд шилжсэн.	100
4	5	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай 2014-10-20 2.5 Нүүрсийг гүн боловсруулах /шингэрүүлэх, хийжүүлэх/, нүүрсний давхаргын метан хийг олборлох технологийг нэвтрүүлж, цэвэр түлш үйлдвэрлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрийг сонгон	Эрдэнэс таван толгой" ХК Таван толгойн ордын Цанхи, Бортээгийн хэсэгт 120 км тууш 2 хэмжээст чичирхийллийн судалгааг хийж, тайлан боловсруулан зүсэлт зургууд гарган нүүрсний давхаргын метан хий агуулах боломжтой давхаргуудыг тодорхойлсон. Тус ордын Бортээгийн хэсэгт нүүрсний давхаргын метан хий олборлох судалгааны 492 метр гүнтэй хий олборлох, 480 метрийн гүнтэй хий шахах 2 цооногийг гурван шатлалаар өрөмдөж, цементаци хийсэн бөгөөд нүүрсний давхаргын метан хийн нөөцийг 40 сая.тонн гэсэн таамаг тооцоог гаргасан. Эрдэнэс таван толгой ХК, Элгэн ХХК болон БНСУ -ын Когаз корпорацитай хамтран ажиллах гэрээ байгуулан нүүрсний давхаргын метан хийнээс ус, нүүрсхүчлийн хийг ялгах туршилтын үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Цаашид метан хийн нөөцийг тогтоох ажлын санхүүжилт болон БХГ-г байгуулах асуудлыг Эрдэнэс метан ХК хариуцан ажиллаж байна.	70

ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл

1	1	"Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийн тухай 2014-08-18 1 БНХАУ-тай "нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхдээ Монгол Улс, БНХАУ-ын хоёр талын хувь оролцоо адил тэнцүү хэмжээтэй байх, талууд өөрт оногдох оролцооны хүрээнд хөрөнгө оруулагч, мэргэжлийн багийг татан оролцуулах эрх нээлттэй байх зарчмыг баримтлах.	Монгол Улсын Уул уурхайн яам болон БНХАУ-ын Синопек корпорацийн хооронд "Монгол Улсад нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төсөл хэрэгжүүлэх тухай" санамж бичиг байгуулсан. Энэхүү Санамж бичгийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 74 дүгээр тогтоолоор Уул уурхайн яамны дэргэд "Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх" төслийн нэгжийг байгуулсан бөгөөд 2014-2015 оны хооронд БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран Монгол Улсын зүүн бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн нүүрснээс синтетик байгалийн хийн үйлдвэр байгуулах, хий экспортлох төслийн урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан. Нийт 36 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдаж, 11000 байнгын ажлын байр бий болгох энэхүү төслийг Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаас гаргасан зөвлөмжөөр Монгол, Хятадын хамтарсан компани байгуулж гэрээний талууд ижил тэнцүү хувь оролцоотой байх, хийн болон ус дамжуулах хоолойн дэд бүтцийг Монгол Улсын төр 100 хувь эзэмших зарчмаар ажиллахыг чиглэл болгосон. Үүний дагуу саналыг БНХАУ-ын талд тавьсан боловч хүлээн авах боломжгүй хэмээн уулзалт, ярилцлагадаа удаа дараа тэмдэглэсэн тул хамтран ажиллах гэрээний өөр хувилбаруудыг судалж үзэхээр хоёр тал тохиролцсон. Хэрэгжих боломжгүй болсон тул хяналтаас хасуулах саналтай	100
	2	2 Нүүрс боловсруулах химийн үйлдвэрүүдийг ажиллуулахад шаардлагатай дэд бүтэц болох хий болон ус дамжуулах хоолойг 100 хувь төрийн эзэмшилд байлгах зарчмыг баримтлах.	Үүний хүрээнд төслийн нэгж 2014 онд БНХАУ-ын Синопек компанитай хамтын ажиллагааны хүрээнд Багануурын уурхай дээр 1-3 тэрбумын үйлдвэр барих хувилбарыг хэлэлцсэн боловч техник, эдийн засгийн тооцооноос харахад Багануур дээр барих үйлдвэр нь эдийн засгийн хувьд ашиггүй, Багануурын нүүрс нь чанарын хувьд хангалттай сайн биш болохыг тогтоогдсон. Иймд БНХАУ-ын талд төслийг 2014 оны 8 сард хамтран гүйцэтгэж дууссан урьдчилсан ТЭЗҮ-д үндэслэн Цайдамнуурын болон Эрдэнэцогтын уурхай дээр тус бүр жилийн 8 тэрбум шоо метрийн хүчин чадалтай Нүүрснээс байгалийн хий үйлдвэр барих нөхцлөөр үргэлжлүүлэх санал хүргүүлсэн.	50
	3	3 Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газруудын зүгээс уг төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн болон татварын орчинг бүрдүүлж, 3 бүтээгдэхүүний үнэ, борлуулалтын хугацаа, ажиллах хүч зэрэг нөхцөл, шаардлагыг Монгол Улсын эрх ашиг, олон улсын жишигт нийцүүлэх зарчмыг баримталж ажиллах.	2013 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталсан БНХАУ-ын Засгийн Газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500сая ам.долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 135 тоот тогтоолын хавсралтад төслийг оруулж батлуулсан. Биелэлт-90%	90
	4	4 Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотыг хийгээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулах нөхцлийг нэн тэргүүнд бүрдүүлэх эхний үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг шуурхай боловсруулах.	Төслийн нэгж БНХАУ-ын Хийн хоолойн зураг төслийн байгууллагуудтай хамтран 2015 оны 3 дугаар сараас 7 дугаар сар хүртэлх хугацаанд Улаанбаатар хотын гэр хорооллыг нүүрсний хийгээр хангах үйлдвэрийн ТЭЗҮ болон нүүрсний хийг дамжуулах хоолойн байгууламжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хорооноос 3 компанийг сонгон авч сонгон шалгаруулалт зарлахаар ажиллаж, холбогдох ажлуудыг бэлэн болгосон. Гэвч Монгол Улсын Засгийн газар 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор уг төслийн санхүүжилтийг Хөшигтийн хөндийн хурдны замын төслийг хэрэгжүүлэх нь, "Улаанбаатар Хөшигтийн хөндийн хурдны зам барих төсөл", "Туул гол дээгүүр Баянзүрхийн 288 у/м болон Сонсголонгийн 289.4 у/м төмөр бетон гүүрийг шинээр барих төсөл"-д олгохоор шийдвэрлэсэн. Биелэлт-50%	50
	5	5 Нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх химийн үйлдвэрүүдийг байгуулах гэрээ хэлэлцээрийг хоёр талын холбогдох яамдын түвшинд байгуулах.	Төслийн хүрээнд жилд 8 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх 2 үйлдвэрийг Цайдамнуурын болон Эрдэнэцогтын ордуудыг түшиглэн байгуулах бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор Эрдэнэцогт болон Цайдам нуурын нүүрсний ордуудад жилд 80 сая тонн нүүрс олборлох нүүрсний ил уурхай байгуулагдаж, хийн үйлдвэрүүд нь 50 жилийн туршид жилд 16 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх юм. Биелэлт-50%	50

2	<p>Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах тухай 2014-12-22</p> <p>2 Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг "Хонгконг Вэлпэк Индастриал" ХХК, "Монгол Гладвилл Увс Петролеум" ХХК-д олгох.</p>	<p>Хэрлэнтохой XVIII талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан "Хонгконг Вэлпэк Индастриал" ХХК-д газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 2015 оны 11-р сарын 13-ны өдрийн Уул уурхайн сайдын 227 дугаар тушаалаар олгов. Увс I талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан "Монголиа гладвил Увс петролеум ХХК-д газрын тос хайх үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг 2015 оны 6-р сарын 17-ны өдрийн Уул уурхайн сайдын 113 дугаар тушаалаар олгов. Хэрэгжсэн тул хяналтаас хасуулх саналтай. Биелэлт 100%</p>	100
---	---	---	-----